

Gefördert durch:



aufgrund eines Beschlusses
des Deutschen Bundestages



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

Монгол улс дахь бордоо ургамал хамгааллын бодисын нийлүүлэлт, түүний үнэлгээ – зах зээлийн судалгаа



Герман-Монголын хамтын ажиллагааны Тогтвортой хөдөө аж ахуй төсөл

Др. Бернд Пёшк

2016 оны 10-11 сар



Герман-Монголын хамтын ажиллагааны
Тогтвортой хөдөө аж ахуй төсөл

Монгол улс дахь бордоо, ургамал хамгааллын
бодисын нийлүүлэлт, түүний үнэлгээ -
зах зээлийн судалгаа



ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГС	4
1 УДИРТГАЛ.....	5
2 ЗАХ ЗЭЭЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВ БАЙДАЛ.....	5
3 ЗАХ ЗЭЭЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТ	8
4 ТАРИАЛАН ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САН	9
5 БОРЛУУЛАГЧ АЖ АХУЙН НЭГЖҮҮД	10
6 ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	12

ТОВЧИЛСОН ҮГС

ААН	Аж ахуйн нэгж
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ЕХ	Европын Холбоо
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ОХУ	Оросын Холбооны Улс
ТЭДС	Тариалан эрхлэлтийг дэмжих сан
УГТХ	Ургамал газар тариалангийн хүрээлэн
УХБ	Ургамал хамгааллын бодис
УХЭШХ	Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХХААХҮЯ	Монгол улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

1 УДИРТГАЛ

ХБНГУ-ын Хүнс, хөдөө аж ахуйн яамны санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй Герман-Монголын хамтарсан “Тогтвортой хөдөө аж ахуй” төслийн хүрээнд Монгол улс дахь бордоо, ургамал хамгааллын бодисын зах зээлийн энэхүү судалгааг гүйцэтгэв. Зах зээл дэх эрэлтийн судалгааг 2016 оны 9-р сард, нийлүүлэлтийн судалгааг тус оны 10-р сард тус тус асуулга, ярилцлагын аргаар гүйцэтгэсэн болно.

Зах зээлийн судалгааг дараахь зорилтуудын дагуу гүйцэтгэсэн болно. Үүнд:

- Монгол улсын зах зээл дэх бордоо, ургамал хамгааллын бодисын эрэлт, нийлүүлэлтийн өнөөгийн түвшинд үнэлэлт дүгнэлт өгөх;
- Бордоо, ургамал хамгааллын бодисын хэрэглээний талаар тариаланчдын шийдвэр гаргах үйл явцад дүгнэлт өгөх, уг шийдвэрт ямар хүчин зүйлс нөлөөлж буйг тогтоох;
- Бордоо, ургамал хамгааллын зах зээлийг боловсронгуй болгох чиглэлээр бодлогын зөвлөмж боловсруулах.

Нийлүүлэлтийн судалгааг гүйцэтгэхдээ нилээд олон борлуулагч, импортлогчидтой уулзаж ярилцсан. Түүнчлэн зах зээлд төрөл бүрээр оролцогч бусад талууд, байгууллага, ААН-үүдтэй уулзаж дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулсан.

2 ЗАХ ЗЭЭЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВ БАЙДАЛ

Монгол улс дахь бордоо, ургамал хамгааллын бодис(УХБ)-ын зах зээл харьцангуй жижиг бөгөөд холбогдох яамд (тухайлбал ХХААХҮЯ, БОАЖЯ, ЭМЯ), агентлаг, мэргэжлийн байгууллагын (МХЕГ, УХЭШХ) хатуу хяналтаар зохицуулагддаг. Бордоо, УХБ-ууд ихэвчлэн БНХАУ болон ОХУ-аас, багахан хувь нь ЕХ-ноос импортлогддог. Дээр дурдагдсан яамд, МХЕГ болон УХЭШХ нь 2006 оноос хойш жил бүр импортоор авах бордоо, УХБ-ын хэмжээ, төрлийг шинэчлэн тогтоож байна. Уг шийдвэр нь нийт хэрэгцээ, үүнд тулгуурлан бүтээгдэхүүний нэр төрөл бүрээр баримжаалан тогтоосон боломжит эрэлтэд үндэслэдэг.

Ийнхүү тооцоолсон боломжит эрэлт нь, ялангуяа бордооны хувьд, Монгол улсын газар тариаланд шаардагдах бодит хэрэгцээнээс бага байдаг. Бордооны өртөг өндөр, мөн тариаланчид бордоо хэрэглэх талаар мэдлэг дутмаг зэрэг шалтгааны улмаас газар тариаланд бордоо хэрэглэхгүй байх, эсвэл шаардагдах норм хэмжээнээс багаар хэрэглэх нь түгээмэл. Жилд шаардагдах нийт бордооны (НРК) хэрэгцээг 150-аас 200 мянган тонн гэж тогтоосон бөгөөд импортоор авч, ашиглаж буй бордооны хэмжээ үүнээс хавьгүй доогуур, барагцаагаар 10 орчим хувьтай нь л дүйцэж байна. Гэвч борлуулагч компаниуд болон ХХААХҮЯ-ны төлөөлөлтэй уулзаж ярилцлага хийх явцад бордоо, УХБ-ын хэрэглээ жилээс жилд өсч буй талаар мэдээлэл өгсөн. ХХААХҮЯ-ны (2016 оны 10-р сард)баримжаалснаар тус бүтээгдэхүүнүүдийн эрэлт жилд 10 орчим хувиар өсч байна.

Тариаланчдын мэдлэг, үр чадвар нэмэгдэх хэрээр хэрэгцээнд нь нийцэх тусгайлсан зарим нэр төрлийн бордоо зах зээлд олдоц багатай байгаад шүүмжлэлтэй хандаж буй нь судалгааны явцад ажиглагдсан. Нэг талаас өнөөг хүртэл тухайн нэр төрлийн бордооны бодит эрэлт бий болоогүй, нөгөө талаас нийлүүлэлтийн тогтсон сувгуудад хамрагдаж амжаагүйн улмаас бордооны нэр төрлийн хомсдол бий болсон гэж үзэж болох юм.

Түүнчлэн өнөөгийн нөхцөл дэх зах зээлийн хатуу чанд хяналт нь уг хомсдолыг бий болгож буй гэж үзэх үндэслэлтэй.

Тариаланчид ургамал хамгааллын технологийн горим, төлөвлөгөө боловсруулж мөрдөх нь ховор бөгөөд ихэвчлэн талбайд ургамлын өвчин хортон тархсан, тухайн таримал үхэх, өвчлөх нь илтээр харагдах зэрэг зайлшгүй нөхцөл байдал үүссэн үед л агрохимийн бүтээгдэхүүн(бордоо, УХБ) хэрэглэдэг. Бордоо нийлүүлэгч гадаадын зарим компаниуд Монгол улс дахь төлөөллийн газруудаараа дамжуулан зарим нэр төрлийн агрохимийн бодисуудыг нийлүүлдэг боловч уг бүтээгдэхүүнүүд нь хэт үнэтэй тул тариаланчдад хүртээмж багатай. Түүнчлэн тариаланчдад ургамал хамгааллын бодис ашиглах мэдлэг, туршлага дутмаг тул өндөр үнэтэй тус бодисуудыг зохистой ашиглаж чадахгүй байх нь их тохиолддог. Мэдлэг дутмагийн улмаас тариаланчид ялангуяа УХБ хэрэглэх хугацааг буруу сонгох, тухайлбал таримлын өвчин, хортны илэрч эхлэх үед нь бус, тархалт нэгэнт газар авсан үед хэрэглэх зэргээр технологийн алдаа гаргаж, тухайн бодисын ашиг тусыг нь гүйцэд үзэж чаддаггүй.

Чанарын баталгаагүй, Хятадаас зөвшөөрөлгүй оруулж ирсэн агрохимийн бүтээгдэхүүн борлуулах явдал нилээд газар авчээ. Уг бүтээгдэхүүнүүдийг худалдан авагчид нь ихэвчлэн бага хэмжээний тариалан эрхэлдэг өрхийн тариаланчид байх бөгөөд бүтээгдэхүүний савлагаан дээрх хятад хэл дээр бичигдсэн ашиглалт, аюулгүй хэрэглээний зааврыг ойлгохгүйн улмаас өөрийн дүраар хэрэглэж, улмаар хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учруулах эрсдэлийг бий болгож байна.

Бордоо, УХБ-ын хэрэглээний ихэнхи хэсгийг бүрдүүлдэг томоохон аж ахуйнууд ихэвчлэн 1000-аас дээш га талбайд буудайн тариалан эрхэлдэг. Ер нь Монгол улсын тариалангийн нийт талбайн ашиглалтыг авч үзвэл 70 гаруй хувьд буудай, 15 орчим хувьд рапс, 4.2 хувьд нь тэжээлийн ургамал тариалж байна. Төмс, хүнсний ногооны тариалан нийт талбайн 4 хүрэхгүй хувийг эзэлдэг.

Дээр дурдсаны дагуу бордоо, УХБ-ын гол хэрэглэгчид нь тариалангийн томоохон аж ахуйнууд, тэр дундаа буудайн тариалан эрхлэгчид юм. Бусад таримлын хувьд агрохимийн бүтээгдэхүүний зах зээлд маш бага хувийг эзэлнэ. Эрэлтийн өнөөгийн төвшинд борлуулагчид буудайн тариалан эрхлэгчдийн хэрэгцээг хангахад түлхүү анхаарч, нийлүүлж буй бүтээгдэхүүнийхээ нэр төрлийг уг борлуулалтын бодлогодоо уялдуулж буйг шүүмжлэх аргагүй юм.

Агрохимийн бүтээгдэхүүн импортлох зөвшөөрөл бүхий ААН-үүдийн тоо жилээс жилд өөрчлөгддөг. Дунджаар 30-40 компани зөвшөөрөл эзэмшдэг бөгөөд үүнээс 10 орчим компани зах зээлийн нийлүүлэлтэд тодорхой байр суурь эзэлдэг гэж үзэж болно. Эдгээр ААН-үүдийн ихэнхи нь буудайн тариалан эрхэлдэг бөгөөд өөрсдийн хэрэгцээндээ зориулан импортлодог.

Агрохимийн бүтээгдэхүүн нийлүүлэгчдийг ерөнхийд нь гурван бүлэгт тоймлон авч үзэж болох юм. Үүнд:

- Өөрийн хэрэгцээндээ зориулан импортлоод хэрэгцээнээс илүү гарсан бүтээгдэхүүнийг борлуулдаг тариалангийн томоохон аж ахуйнууд (жишээ нь Гацуурт),

- ТЭДС-ийн худалдан авалтын тендерт оролцох замаар агрохимийн бүтээгдэхүүн нийлүүлдэг ААН-үүд (эдгээр нь ихэвчлэн сүүлийн жилүүдэд байгуулагдсан),
- Агрохимийн бүтээгдэхүүн байнга борлуулагчид, жишээ нь УХБ-ын бодис нийлүүлдэг Шим ХХК.

Дээрх гурван төрлийн нийлүүлэгчдээс гадна Хятадаас ихэвчлэн зөвшөөрөлгүй оруулж ирсэн агрохимийн бүтээгдэхүүн борлуулдаг худалдаачид, ААН-үүд уг зах зээлд тодорхой байр суурь эзэлж байна.

Агрохимийн бүтээгдэхүүний импортын санхүүжилтийн хамгийн том эх үүсвэр нь ТЭДС-ийн худалдан авалтын тендер юм. Уг худалдан авалт жил бүр явагддаг бөгөөд тендерт агрохимийн бодис нийлүүлэгч ихэнх ААН-үүд оролцдог. Өнгөрсөн 2016 онд 7,961 тонн бордооны импортыг ТЭДС санхүүжүүлжээ. Тус сангийн тендерээр нэг нэр төрлийн нийлмэл бордоо (N20/P15/K21), 11 нэр төрлийн УХБ импортлогдсон бөгөөд УХБ-уудын ихэнхи хэсгийг гербицид бүрдүүлж байна. ТЭДС-аас 2016 онд тариаланчдад бордоо нийлүүлэхдээ 40 гаруй хувийн үнийн хөнгөлөлт үзүүлсэн нь өмнөх жилүүдэд үзүүлсэн хөнгөлөлтөөс давсан үзүүлэлт юм. ТЭДС-ийн тендерээр 2016 онд нийлүүлэгдсэн агрохимийн бодисууд Хятадаас импортлогдсон бөгөөд тус сангийн 6 салбараар дамжуулан тариаланчдад олгогджээ. Тариаланчид уг бүтээгдэхүүнүүдийг худалдан авахдаа үнийн 30%-ийг төлөх бөгөөд үлдэх 70%-ийг зээлж, намар хурааж авсан ургацаараа эргэн төлдөг. Эргэн төлөлтийн хувь хэмжээг ТЭДС-ийн зүгээс нарийвчилсан тоогоор илэрхийлээгүй боловч 100%-д хүрдэггүй болохыг дурдаж байсан (ТЭДС, 2016 оны 10-р сар).

Монгол орны тариалангийн хөрс

Монгол орны нийт тариалангийн талбайн ихэнх хэсэгт хээрийн хар хүрэн ба хүрэн хөрс зонхилдог. Хөрсний үржил шимт давхарга харьцангуй нимгэн бөгөөд тариалангийн төв бүсийн Төв, Сэлэнгэ аймгуудад 30 см-аас ихгүй. Эдгээр аймгуудад тариалангийн талбайнууд ихэвчлэн голын ай сав дагуу буюу уулын ар хөндийгээр байршсан байдаг нь эдгээр байрлал дахь хөрсний үржил шимт давхарга харьцангуй зузаан, чийг хуримтлуулах чадвар харьцангуй өндөр байдагтай холбоотой. Тариалангийн хөрс голчлон хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй, 3-4 хувийн органик бодисын агууламжтай, сүл хүчиллэгээс саармагийн хооронд буюу рН нь 6.0-7.0 орчим. Хөрсний кальцийн агууламж харьцангуй өндөр боловч фосфат хомсдолтой. Хөнгөн механик шинж чанартайн улмаас чийгийн багтаамж бага, элэгдэлд өртөх эрсдэл ихтэй. Зохисгүй ашиглалтын улмаас хөрсний элэгдэл эрчтэй явагдаж буй бөгөөд зөвхөн тариалангийн газарт бус, мөн бэлчээрийн хөрсний элэгдэл, эвдрэл нэмэгдэж буй нь байгаль орчны тулгамдсан асуудлуудын нэг болоод байна.

Хөрсний үржил шим алдагдахад хүргэж буй хүний зохисгүй үйл ажиллагаанд бэлчээрийг даац хэтрүүлэн ашиглах, хариуцлагагүй уул уурхай, хучлагатай ба хучлагагүй зам тавих, ой мод устгах зэргийг нэрлэж болно.

Тариалангийн хөрсний доройтол нь газар тариалангийн салбарт тулгамдсан томоохон асуудал болоод байна. Ойролцоогоор 0.7 сая га талбай тариаланд ашиглагдах боломжгүй болтлоо доройтжээ. Нийт тариалангийн талбайн 47%, үүний дотор 13% нь хүчтэй, 28% нь дунд зэрэг, 59% нь хөнгөн доройтолд өртсөн байна. Монголын Хөрс судлалын нийгэмлэгийн судалгаанаас үзвэл сүүлийн 30 жилд тариаланд ашигласан газрын га тутмаас 35-50 тонн хөрс салхинд хийсч алдагджээ. Хөрсний доройтол ба уур амьсгалын дулаарлын хавсарсан нөлөөллийн улмаас хөрсний өнгөн давхарга дахь чийгийн алдагдал ихэсч, органик бодисын (ялзмагийн) агууламж эрчтэй багасч буй бөгөөд улмаар салхины элэгдэлд өртөх аюул нэмэгдэх, хөрсний чийг багтаамж буурах, хөрс давсжих, хөрсний нягтрал ихсэх хэрээр ус урсаж алдагдах нь ихсэх, гадаргын ан цав үүсэх зэрэг үр дагавар үүсч байна.

Элэгдэл, доройтолд мэдэгдэхүйц хэмжээнд өртөөгүй тариалангийн талбайн ялзмагийн агууламж дунджаар 2.64%, элэгдэл, доройтолд өртсөн талбайд үүнээс 40 хүртэл хувиар бага байна. Ялзмагийн агууламж нь багатай хөрсний үржил шим, чийг хадгалах чадвар нь мөн бага байдаг.

Хөрсний элэгдэл, доройтлын талаар олон жилийн турш судалгааны ажлууд хийгдэж, үүнд олон улсын байгууллагууд ч дэмжлэг үзүүлж ирсэн бөгөөд газар тариалан, мал аж ахуй эрхэлж ирсэн уламжлалт арга барилыг цаашид хөрсний үржил шимийг сайжруулах чиглэлээр өөрчлөн сайжруулахад анхаарч ажиллаж байна. Тухайлбал газар тариаланд ээлжлэн тариалалтыг нэвтрүүлэх, хөрсөнд ургамлын хучлага үлдээх замаар салхины элэгдлээс хамгаалах, органик бордоо ба ногоон бордуур ашиглах зэрэг технологийн зөвлөмжүүдийг мөрдөх шаардлагатай. Уг зөвлөмжүүдийг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд Монгол оронд таримлын ургалтын хугацаа хэт богино, сэлгээнд төрөл бүрийн таримлууд оруулахад тухайн нутгийн хөрс тохирохгүй байх зэрэг бэрхшээлүүд тулгарч байна.

3 ЗАХ ЗЭЭЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТ

Монгол улсад бордоо, УХБ-ын импортлох үйл явц нь хатуу хяналтын дор явагддаг. Импортын зөвшөөрөл бүхий ААН-үүд шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн импортлохын тулд эхлээд тус бүтээгдэхүүнийг импортлох зөвшөөрөл авах ёстой. Зөвшөөрөл авах шат дамжлагуудыг хялбарчлан дүрсэлбэл эхлээд тухайн ААН оруулж ирэхээр хүсэлт гаргасан бордоо буюу УХБ-ын танилцуулгыг дээжийн хамт МХЕГ-т хүргүүлнэ. Улмаар тус бүтээгдэхүүнийг Монгол орны хөрс, цаг уурын нөхцөлд түрших ажлыг 2 жилийн хугацаанд УХЭШХ хариуцан, өөрийн туршилтын талбайд гүйцэтгэнэ. Туршилтын үр дүнг ХХААХҮЯ, БОАЖЯ болон ЭМЯ-нд хүргүүлэх бөгөөд эдгээр гурван яам зөвшөөрсөн тохиолдолд ХЗДХЯ-наас тус бүтээгдэхүүнийг Монгол улсад импортлох, борлуулах зөвшөөрөл олгож, зохих жагсаалтад багтаана. Шинэ нэр төрлийн бордоо, УХБ импортлох зөвшөөрөл авах энэхүү шат дамжлагуудад гарах нийт зардлыг хүсэлт гаргасан ААН-ээс гаргуулна.

ААН-үүд агрохимийн бүтээгдэхүүн импортлох, борлуулах зөвшөөрөл авахын тулд Монгол улсын стандартад нийцэх тодорхой нөхцлүүдийг, ялангуяа агуулах савны тоноглолд тавих шаардлагуудыг хангасан байх шаардлагатай. Зөвшөөрлийг ХХААХҮЯ-наас олгох бөгөөд тухайн ААН-ийн үйл ажиллагаа, тоноглол зэргийг МХЕГ-аас тогтмол шалгана. Тухайн жилд зөвшөөрөгдсөн агрохимийн бүтээгдэхүүн импортлоход хилийн боомт дээр МХЕГ-аас тухайн бүтээгдэхүүн жинхэнэ эсэхийг, чанар, стандартын шаардлага хангасан эсэхийг дээж авч шалгадаг. Агрохимийн бүтээгдэхүүний борлуулалтыг жил бүрийн эцэст ААН-үүд МХЕГ-т тайлагнана. Зохих журмын дагуу агрохимийн бүтээгдэхүүн агуулагдаж буй сав, канистрыг хоосорсных нь дараа тухайн хэрэглэгч (тариаланч) хаяж устгах шаардлагатай боловч уг журам амьдралд хэрэгждэггүй байна (ХХААХҮЯ).

Монгол улсад импортлож болох бордоо, УХБ-ын жагсаалтыг жил бүр шинэчлэн баталдаг. Тус жагсаалтад зөвшөөрөгдсөн бүтээгдэхүүнүүдийн нэр төрөл, чанарын үзүүлэлтүүдээс гадна ашиглах зориулалт ба оруулж ирэх дээд хэмжээг нь зааж өгдөг. Зориулалтыг жишээлбэл газар тариалан, ойн аж ахуй, буудайн силосын цэвэрлэгээ гэх мэтээр тодотгож өгнө. Импортлох дээд хэмжээний хувьд ААН-үүдийн импортлох хэмжээ нийт дүнгээрээ зөвшөөрөгдсөн дээд хэмжээнээс хэтэрвэл хүсэлт гаргасан ААН-үүдэд квот олгох замаар зохицуулна.

Монгол улсад импортлож болох бордоо, УХБ-ын жагсаалтыг 2006 оноос жил бүр ХХААХҮЯ болон УХЭШХ хамтран боловсруулж, дээр дурдагдсан гурван яам батламжилдаг. ХХААХҮЯ болон УХЭШХ-ээс авсан мэдээллээс үзвэл бордоо, УХБ-ын импортын бодит хэмжээ жагсаалтад заасан хэмжээнд хүрдэггүй байна. Энэ нь сүүлийн жилүүдэд агрохимийн

бүтээгдэхүүний хэрэглээ тухайн жилд төлөвлөгдсөн хэмжээнээс доогуур төвшинд байсныг илэрхийлж байна.

Түүнчлэн хэрэв жагсаалтад багтсанаас өөр нэр төрлийн агрохимийн бүтээгдэхүүн оруулж ирэх шаардлага үүсвэл ямар шат дамжлагыг дамжих шаардлагатай болохыг БОАЖЯ-наас лавлахад шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн импортлоход засгийн газрын шийдвэр зайлшгүй шаардлагатай гэсэн хариу өгсөн болно.

Судалгааны явцад цуглуулсан мэдээллээс дүгнэхэд бордоо, УХБ-ын борлуулалт нь төрийн хатуу хяналт, зохицуулалтын дагуу явагддаг байна. Энэ нь агрохимийн бүтээгдэхүүний зах зээлийн хөгжилд сөргөөр нөлөөлж буй бөгөөд борлогдох бүтээгдэхүүний нэр төрлийг хязгаарлах хандлагатай байна. Шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн импортлоход тавьж буй хатуу шаардлага, зөвшөөрөл авах олон шат дамжлага нь нэг талаар зөв боловч нөгөө талаар агрохимийн бүтээгдэхүүн хууль бусаар импортлох, борлуулахад түлхэц болох эрсдэлтэй. Судалгааны явцад БОАЖ-ын Сайдын зөвлөхөөс, агрохимийн бүтээгдэхүүний импортын хууль эрх зүйн орчинд удахгүй өөрчлөлт оруулна гэсэн мэдээлэл авсныг энд тэмдэглэх нь зүйтэй.

4 ТАРИАЛАН ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САН

Бордоо, УХБ-ын зах зээлийн хамгийн чухал оролцогч болох ТЭДС нь 1992 онд байгуулагдсанаасаа хойш тариалан эрхлэгчдэд хэрэгцээтэй орц материалуудыг хөнгөлөлттэй үнээр олгож иржээ. Тариаланчдад нийлүүлдэг гол бүтээгдэхүүнүүдэд нь үр, шатахуун, бордоо, УХБ, ХАА-н техник, сэлбэг хэрэгсэл багтана. ТЭДС нь Хөтөл, Булган, Сүхбаатар, Дархан, Хархорин, Улаанбаатарт нийт 6 салбартай, 150 гаруй ажиллагсадтай бөгөөд тариаланчдаас бүүдай хүлээн авах, хадгалах зориулалтаар нийт 184 мянган тонны багтаамжтай силосууд эзэмшдэг. 2016 онд тус сангаас тариаланчдад анх удаа эрс хөнгөлөлттэй нөхцлөөр бордоо олгосон.

ТЭДС-аас агрохимийн бүтээгдэхүүн худалдан авах тендер жил бүрийн хавар, ихэвчлэн 5-р сард зарладаг. 2016 онд тус тендерт шалгарсан 10 компани УХБ, 4 компани бордоо импортложээ. Эдгээр бүтээгдэхүүнүүдийг бүгдийг нь Хятадаас оруулсан бөгөөд ТЭДС-ийн 6 салбар дахь агуулахуудад тараан байршуулсан байна. Уг агуулахуудад МХЕГ-аас тогтмол хяналт тавьж ажилладаг.

ТЭДС-аас нийлүүлж буй бүтээгдэхүүнүүдийг тус санд бүртгэлтэй тариалан эрхлэгчид худалдан авах боломжтой. ТЭДС-ийн мэргэжилтний өгсөн мэдээллээс үзэхэд бүртгэлтэй нийт 3000 ААН-ээс 800 нь л тогтмол тариалан эрхэлдэг байна. Тариаланчид ТЭДС-аас бүтээгдэхүүн худалдан авахдаа 30%-ийн урьдчилгаа төлбөр төлж, үлдэх 70%-ийг нь зээлэх ба ургацаасаа эргэн төлдөг. 2016 онд ТЭДС-ийн тендерээр нэг нэр төрлийн бордоо, 10 нэр төрлийн УХБ (үүнд ихэвчлэн гербицид) импортлогджээ.

ТЭДС-аас түүнчлэн харилцагч тариаланчиддаа зөвлөх үйлчилгээ үзүүлдэг байна. 2016 онд НРК бордооны зах зээлийн үнэ 1.2 сая төгрөг/тн байсан бол тус сангаас тонныг нь 400 мянган төгрөгөөр борлуулжээ. Хамгийн их борлуулалттай гербицидэд Хятадад

үйлдвэрлэгдсэн, 6500 төг/л үнээр борлогдсон Раунд Ап ба 18200 төг/л үнээр борлогдсон Пума супер багтана.

Судалгаанд хамрагдсан ТЭДС-ийн мэргэжилтний хэлснээр 2017 онд тус сангаас худалдан авалтын тендер зарлах эсэх, үүнд хэдий хэмжээний төсөв зарцуулах нь одоогоор тодорхойгүй байна.

ТЭДС нь бордоо, УХБ-ын зах зээлд маш чухал үүрэг гүйцэтэдэг. Бидний уулзсан борлуулагч компаниудын нилээд нь зөвхөн ТЭДС-ийн худалдан авалтын тендерт оролцох замаар борлуулалт хийдэг болох нь харагдаж байсан. 2016 онд тус сангийн тендерээр нийт 7,961 тонн бордоо импортлогдсон нь тухайн жилийн нийт импортын үнэмлэхүй хувийг эзэлж байна. Бусад эх үүсвэрийн импорт нийтдээ дөнгөж 1000 орчим тонн байв.

ТЭДС-аас үзүүлдэг үнийн хөнгөлөлт нь голчлон жижиг, дунд хэмжээний тариалангийн аж ахуйнуудад чиглэх боловч үр шим хүртэгчдэд мөн томоохон аж ахуйнууд ч багтдаг. Жижиг тариаланчид бордоо зэрэг зарим орцыг хөнгөлөлттэй үнээр ч авч дийлэхгүй байх нь олонтаа тохиолддог байна.

5 **БОРЛУУЛАГЧ АЖ АХУЙН НЭГЖҮҮД**

ТЭДС-ийн тендерээс хамааралгүйгээр бордоо, УХБ импортлодог цөөн тооны ААН байгаагийн ихэнхийг өөрсдийнхөө хэрэгцээнд зориулан импортлоод, хэрэгцээнээсээ илүү гарсныг борлуулдаг тариалангийн томоохон аж ахуйнууд (жишээ нь Гацуурт компани) эзэлж байна. Түүнчлэн зарим ААН-үүд агробизнесийн бусад чиглэлээр ажилладаг боловч бордоо, УХБ-ын бодисын импорт, худалдааг хавсран эрхэлдэг бөгөөд уг ААН-үүд ихэвчлэн 2010 оноос хойш байгуулагджээ. Бордоо, УХБ-ын борлуулалт эрхэлдэг цөөн тооны төрөлжсөн ААН-үүд (жишээ нь “Шим” компани) ажиллаж байна.

Монголд борлогдож буй бордоо, УХБ-ыг ихэвчлэн Хятад улсаас импортлодог. Түүнчлэн нилээд хэмжээгээр ОХУ-аас, мөн багахан хэмжээгээр Европын Холбооноос импортлодог. Үнийн хувьд Хятадын бүтээгдэхүүнүүд хамгийн хямд бөгөөд бусад орнуудаас импортлосон бүтээгдэхүүнүүдийн үнийн 20-30 хувиас хэтэрдэггүй байна. Нийлүүлэлтийн логистикийн схем ерөнхийдөө “ачааны автомашин - галт тэрэг – ачааны автомашин – агуулах – тариаланчид” гэсэн дараалалтай. Импортын бүтээгдэхүүнүүд Монголд галт тэргээр орж ирэх бөгөөд хилийн мэргэжлийн хяналтын шалгалтын дараа автомашинд ачигдаж борлуулагч ААН-ийн агуулахад хүргэгдэнэ. Эндээс шууд борлогдох ба тээврийг худалдан авсан тариаланчид өөрсдөө хариуцна. Судалгааны явцад уулзсан импортлогчдын зүгээс импортлохтой холбоотой бичиг баримт бүрдүүлэх, захиргааны шат дамжлага нь хэт нүсэр, цаг шаардсан ажил болохыг шүүмжилж байв.

Бордоо, УХБ борлуулагч компаниудын гол худалдан авагчид нь буудайн тариалан эрхэлдэг, 5000 га-аас дээш эргэлтийн талбайтай томоохон аж ахуйнууд бөгөөд 1000 га-аас бага талбайтай аж ахуйнуудад бүтээгдэхүүнээ борлуулах нь харьцангуй хомс. Судалгаанд хамрагдсан борлуулагч компаниудыг өгсөн мэдээллээс үзэхэд бага хэмжээнд тариалан эрхлэгчдэд зориулан борлуулалт эрхлэх нь борлуулагчдад өөрсөд нь ашиг муутай. Нэн

ялангуяа ОХУ, ЕХ-ноос импортлосон бордоо, УХБ-ын үнэ жижиг тариаланчдын хувьд хэт өндөр тусдаг байна.

Судалгаанд хамрагдсан борлуулагч компаниуд бүгдээрээ ТЭДС-ийн худалдан авалтын тендерт оролцдог буюу оролцох эрмэлзэлтэй болохоо илэрхийлж байв. Тендерт оролцож байсан компаниудын хувьд борлуулалтынхаа ихэнх хувийг тендерээр дамжуулж, багахан хувийг тариаланчдад шууд борлуулах замаар гүйцэтгэжээ.

Бордоо, УХБ борлуулдаг зарим томоохон ААН-үүд өөрсдөө буудайн тариалан эрхэлдэг. Судалгаанд хамрагдсан нэг компани 48 мянган га-д буудай тариалдаг бол өөр нэг компани 18 мянган га-д тариалдаг. Эдгээр компаниуд өөрсдөө буудайн тариаландаа бордоог байнга хэрэглэж хэвшээгүй байна.

Дотоодод бордоо үйлдвэрлэх үйл ажиллагааг цөөн хэдэн компани эрхэлж байна. Одоогоор зах зээлд бүтээгдэхүүнээ нийлүүлж буй 2 компани байгуулагдаад удаагүй бөгөөд ашигт ажиллагааны төвшинд хараахан хүрээгүй боловч туршилтын төвшингөөсөө түргэн ахиж, үйлдвэрлэлийнхээ цар хүрээг нэмэгдүүлэх бүрэн дүүрэн эрмэлзэлтэйгээр ажиллаж байна.

Ургамал хамгааллын бодисын зах зээлд хамгийн нөлөөтэй ААН нь Шим ХХК юм. Тус компани нь ихэвчлэн ОХУ-аас УХБ импортлодог бөгөөд гербицидийг хамгийн сайн борлуулдаг. Хятадын хямд бүтээгдэхүүний импорт болон төгрөгийн ханшийн уналт нь ам.доллараар бүтээгдэхүүнээ худалдан авдаг уг компанийн үйл ажиллагаанд хүндрэл учруулж байна.

Судалгааны дүнгээс үзвэл бордоо, УХБ-ын зах зээл ТЭДС-аас хүчтэй хамаардаг болох нь харагдаж байна. Тариаланд ямар нэр төрлийн бордоо, УХБ хэдий хэмжээгээр хэрэглэх нь тус сангаас зохион байгуулсан худалдан авалт, нийлүүлэлттэй шууд холбоотой. ТЭДС-аас худалдан авалтын тендер зарлахаа зогсоох тохиолдолд Монголд импортоор орж ирэх бордоо, УХБ-ын хэмжээ эрс буурах хандлага ажиглагдаж байна. Үүнийг дагаад тариаланчдын хэрэглээ буурах нь гарцаагүй. Өөрсдийн хэрэгцээнд импортлодог томоохон ААН-үүдийн хувьд ТЭДС-аас хамааралгүйгээр үргэлжлүүлэн хэрэглэсээр байж болох ч бага, дунд хэмжээнд тариалан эрхэлдэг олон тариаланчид бордоо хэрэглэхээ бүрмөсөн болих ч магадлалтай.

1-р хүснэгт: Судалгаанд хамрагдсан байгууллага, ААН-үүд

ААН/Байгууллага	Товч танилцуулга
Гацуурт ХХК	Тус компани нь 1993 онд байгуулагдсан, нийт 20 гаруй компани, нийт 1500 гаруй ажиллагсад бүхий холдинг юм. Нийт 45,000 га талбайд буудай тариалдаг. ОХУ-аас бордоо, УХБ импортлодог бөгөөд хэрэгцээнээсээ илүү гарсан бүтээгдэхүүнүүдээ борлуулдаг. Гол худалдан авагчид нь тариалангийн томоохон аж ахуйнууд.
Тариалан эрхлэлтийг дэмжих сан	ТЭДС нь агрохимийн бүтээгдэхүүний хамгийн том нийлүүлэгч. Тус сан нь 1992 онд байгуулагдсан ба тариаланчдад үр, бордоо, УХБ, ХАА-н техник, сэлбэг хэрэгсэл, шатахуун зэрэг орц материалуудыг нийлүүлдэг. Түүнчлэн нийт 184 мянган тонны багтаамжтай силосууддаа тариаланчдаас буудай хүлээн авдаг. 2005 оноос буудайн тариаланг дэмжих чиглэлээр төрөлжсөн сан бүрдүүлэн

	ажиллаж байна. Нийт 150 орчим ажиллагсадтай. ТЭДС жил бүр бордоо, УХБ худалдан авах тендер зарлаж, худалдан авсан бүтээгдэхүүнүүдээ тариаланчдад хөнгөлөлттэй нөхцлөөр нийлүүлдэг. 2016 онд тус сангийн тендерээр 10 компани УХБ, 4 компани бордоо импортлосон. Тендерт шалгарсан компаниуд бордоо, УХБ-оо бүгдийг нь Хятад улсаас оруулсан.
Монгол экологийн бордоо ХХК	Тус компани дотоодод бордоо үйлдвэрлэх зорилгоор 2016 онд байгуулагдсан. Жилд 2000 тонн бордоо үйлдвэрлэх хүчин чадалтай бөгөөд 2016 оны 6-р сард ажиллаж эхэлснээсээ хойш 20-30 тонныг үйлдвэрлээд байна. Бүтээгдэхүүнийхээ маркетинг, нийлүүлэлтийн төлөвлөгөө хараахан боловсруулж амжаагүй.
Энсада трактрон ХХК	Тус компани 2010 оноос агробизнесийн үйл ажиллагаа эрхэлж байна. Бизнесийн гол чиглэл нь ХАА-н техникийн импорт, борлуулалт. Түүнчлэн 18 мянган га талбайд буудайн тариалан эрхэлдэг бөгөөд ТЭДС-ийн худалдан авалтын тендерт оролцож, бордоо импортлосон туршлагатай. Бордоог тариалангийн томоохон аж ахуйнуудад борлуулдаг.
Эко Грийн ХХК	Тус компани 2015 онд байгуулагдсан бөгөөд 2016 оноос эхлэн Герман улсаас УХБ импортлон борлуулж байна. ТЭДС-ийн худалдан авалтын тендерт амжилттай оролцож байсан. Худалдан авагчид нь тариалангийн томоохон аж ахуйнууд ба силос эзэмшигчдийг хамарна.
Хийрэв ХХК	Тус компани 2012 онд байгуулагдсан. Органик хаягдал ашиглан, таримал ургамлын биологийн шинж чанарыг сайжруулах үйлчилгээтэй тусгай нэр төрлийн бордоо жилд 20-30 тонныг үйлдвэрлэдэг.
Цэцүүх трэйд ХХК	Тус компани 1996 онд байгуулагдсан бөгөөд лаборатори, эмнэлэг, уул уурхайн тоног төхөөрөмж борлуулдаг. Түүнчлэн химийн бодисууд, түүний дотор бордоо, УХБ импортлон борлуулдаг. ТЭДС-ийн худалдан авалтын тендерт оролцож байсан. Нийт 30 орчим ажиллагсадтай.
Эм Эс Эм ХХК	Гадаадын MSM компанийн охин болох Эм Эс Эм ХХК нь Монголд 16 дахь жилдээ ажиллаж байна. ХАА-н техник, сэлбэг хэрэгслийг худалдаа эрхэлдэг. 2014 оноос эхлэн Герман улсаас УХБ импортлож, 2016 эхлэн борлуулж байна. Худалдан авагчид нь 1000 га-аас дээш талбайд тариалан эрхэлдэг томоохон ААН-үүд.
Шим ХХК	Тус компани нь 1990 онд байгуулагдсан, УХБ-ын борлуулалтаар төрөлжсөн ААН юм. Бүтээгдэхүүнүүдээ ихэвчлэн ОХУ-аас импортлодог бөгөөд ТЭДС-ийн худалдан авалтын тендерт оролцож байсан. Гол бүтээгдэхүүн нь буудайн тариаланд ашиглах зориулалт бүхий гербицид.

6 ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Судалгааны үр дүнгээс дүгнэхэд Монгол улс дахь агрохимийн бүтээгдэхүүний зах зээл дараахь онцлог шинж чанаруудыг агуулж байна:

- Тус зах зээл нь өнөөгийн байдлаар харьцангуй жижиг. Тариаланчдын бордооны хэрэглээ төлөвшөөгүй, УХБ-ыг зөвхөн гарцаагүй шаардагдсан үед хэрэглэж байгаа тул ойрын 10 жилдээ тус зах зээл жижиг хэвээр байх магадлалтай.

- Уг зах зээл нь төрийн хатуу хяналтаар зохицуулагддаг. Зах зээл дэх нийлүүлэлтийн хэмжээ, бүтээгдэхүүний нэр төрөл нь төрийн оролцооноос шууд хамаардаг. Бордоо, УХБ-ын хэрэглээг жил тутамд урьдчилан тооцоолдог арга барил нь цаг уурын ба бусад хүчин зүйлийн нөлөөн дор явагддаг газар тариалангийн үйлдвэрлэлд тохиромжгүй гэж үзэж байна.
- Тариаланчдад нийлүүлэгдэж буй бордоо, УХБ-ын нэр төрөл хязгаарлагдмал.
- Бага хэмжээнд тариалан эрхлэгчид Хятад улсаас зөвшөөрөлгүй оруулж ирсэн агрохимийн бүтээгдэхүүнүүдийг худалдан авч байна. Тус бүтээгдэхүүнүүдийн хэрэглээ нь үр ашиггүйгээс гадна хүний эрүүл мэнд, байгаль орчинд хор хохирол учруулах өндөр эрсдэтэй.
- Зах зээлд нийлүүлэгдэж буй бордооны хэмжээ ТЭДС-ийн төсвийн чадавхиас шууд хамаардаг. ТЭДС нь зах зээлийн хамгийн чухал оролцогч бөгөөд хувийн хэвшлийн нийлүүлэгчдэд зах зээлийн орон зайг бий болгож байна. Гэвч тус сан нь өөрөө урт хугацаанд тогтвортой ажиллах баталгаагүй, тухайн жилийн төсвийнхөө хүрэлцээнээс хамааран үйл ажиллагааны цар хүрээ нь хэлбэлздэг. 2016 оны 10-р сарын байдлаар тус сангаас 2017 онд худалдан авалтын тендер зарлах эсэх нь тодорхойгүй байв. Үүнээс үзэхэд газар тариалангийн салбарын бордоо, УХБ-ын хангамжийн тогтолцоо үнэн хэрэгтээ маш хэврэг, хэзээ ч нурж унаж мэдэхээр байна.
- Зах зээл дэх хувийн хэвшлийн гол оролцогчид нь газар тариалангийн томоохон аж ахуйнууд бөгөөд эдгээр компаниудын борлуулалт нь мөн бүүдайн тариалан эрхэлдэг томоохон аж ахуйнуудад чиглэдэг. Жижиг, дунд хэмжээний тариаланчдад бордоо, УХБ нийлүүлэх сонирхол бага.
- Дотоодод бордоо үйлдвэрлэх хоёр компани шинээр байгуулагдан ажиллаж байна. Уг компаниуд байгуулагдаад дөнгөж нэг жил болж буй бөгөөд бордоо үйлдвэрлэлийн ашигт ажиллагааны төвшинд хараахан хүрч амжаагүй байна.

Бордооны хэрэглээг дэмжих, төлөвшүүлэхийн тулд зах зээлийн зохицуулалтыг шинэчлэх шаардлагатай. Хэдийгээр бордооны борлуулалт, хэрэглээг төрөөс зохицуулах нь зайлшгүй боловч импорт, хэрэглээний хэмжээг импортлогчид ба хэрэглэгчид өөрсдөө шийддэг байх нь зүйтэй. Газар тариаланд ашиглах бордоо нь дараахь шаардлагуудыг хангасан байна.

Үүнд:

- Таримал ургамлын өсөлт хөгжилт, хөрсний үржил шимд эерэг нөлөөтэй;
- Монгол улсын стандартын шаардлагыг хангасан;
- Хэрэглээ нь байгаль орчинд хор нөлөөгүй.

Бордоо, УХБ-ын зах зээлийн эрх зүйн орчин, төрийн зохицуулалтыг сайжруулан өөрчлөх, үүнд ЕХ-ны стандартуудаас жишээ авч ашиглахыг зөвлөж байна.

Бордоо, УХБ-ын зах зээл импортын эх үүсвэрээс хэт хараат, төлбөрт нь их хэмжээний валютын урсгал гадагш алдагдаж буй байдлыг цаашид залруулахын тулд дотоодын үйлдвэрлэлийг дэмжихийг зөвлөж байна. Үүний тулд хэрэглээний судалгааг эрчимжүүлэх, бордоо, УХБ үйлдвэрлэлийн чиглэлээр гарааны компани байгуулах, хөрөнгө оруулах санаачлагуудыг тал бүрээр дэмжих нь зүйтэй.

Агрохимийн бүтээгдэхүүний зах зээл дэх хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, төрөөс уг зах зээлд зарцуулж буй төсвийг хэмнэх үүднээс ТЭДС-аас тариаланчдад бүтээгдэхүүн

нийлүүлж буй бүтцийг залруулах боломжийг судлахыг зөвлөж байна. Төрөөс цаашид тариаланчдад хэрэгцээтэй орц материалыг нь хөнгөлөлтэй нөхцлөөр олгох дэмжлэгээ үргэлжүүлэх тохиолдолд үүнд ТЭДС-г заавал оролцуулах албагүй, харин үнийн зөрүүг хувийн хэвшлийн ААН-үүдэд шууд олгох байдлаар шийдвэрлэх нь илүү үр дүнтэй, улсын төсөвт хэмнэлттэй байж болох юм.

Буудайнаас бусад төрлийн таримал ургамлын тариаланг дэмжих чиглэлээр цаашид төрөөс түсгайлсан хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, үүнтэй уялдуулж тариаланчдад хүртээмжтэй бордоо, УХБ-ын нэр төрлийг нэмэгдүүлэх нь зүйтэй. Хэрэгцээтэй боловч харьцангуй бага хэмжээгээр борлогдох зарим нэр төрлийн бордоо, УХБ-ыг хангамжийг нэмэгдүүлэх асуудал нь борлуулагч ААН-үүдийн хувьд ашиггүй байж болох талтай учраас төрөөс тодорхой хугацаанд дэмжлэг үзүүлэх нь зүйтэй боловч. Уг хөтөлбөрийг боловсруулахын тулд юуны өмнө буудайнаас бусад таримал тариалж буй, цаашид тариалах тариаланчдын бордоо, УХБ-ын хэрэгцээг тодорхойлох шаардлагатай.

ХАВСРАЛТ 1

Бордоо, ургамал хамгааллын бодисын нийлүүлэлтийн судалгааны асуулгын хуудас

I. Аж ахуйн нэгжийн талаарх мэдээлэл

1) ААН-ийн танилцуулга (байгуулагдсан он, ажиллагсадын тоо, бүтээгдэхүүн үйлчилгээ);

ААН-ийн нэр:	
Хаяг:	
Утас:	
Имэйл:	
Уулзсан хүний нэр, албан тушаал:	
Байгуулагдсан он:	
Үйл ажиллагааны зорилго:	
Үйл ажиллагааны чиглэлүүд:	
Гол бүтээгдэхүүн, үйлчилгээ:	
Ажиллагсадын тоо:	
Тайлбар:	

II. Судалгааны асуултууд:

2) Бордоо, УХБ-ын худалдан авалттай холбоотой асуултууд (ханган нийлүүлэлтийн эх үүсвэр, худалдан авах хугацаа, давтамж, жилд худалдан авах хэмжээ, чанарын шаардлага, хяналт, худалдан авалтын логистик, худалдан авах үнэ, худалдан авалтын давуу, сул талууд ба боломж, аюул - SWOT);

Танай ААН ямар нэр төрлийн бордоо, УХБ борлуулдаг вэ?	
Борлуулдаг бүтээгдэхүүн тус бүрийн эх үүсвэр (Улс/Нийлүүлэгч)?	
Танай ААН борлуулдаг бүтээгдэхүүнүүдээ жилийн аль хугацаанд худалдаж авдаг вэ?	
Худалдан авалтын давтамж (жишээ нь долоо хоног бүр, сар бүр г.м.)?	
Жилд худалдан авах хэмжээ?	

Худалдан авалтын үеэр бүтээгдэхүүнүүдэд тавигдах чанарын шаардлага?	
Бүтээгдэхүүн ханган нийлүүлэлтийн үед чанарын хяналтыг хэрхэн зохион байгуулдаг вэ?	
Бүтээгдэхүүнийг ханган нийлүүлэхэд тээвэрлэлт хэрхэн явагддаг вэ?	
Бүтээгдэхүүн тус бүрийг ямар үнээр худалдан авдаг вэ?	
Худалдан авалтын үед ямар бэрхшээлүүд тулгардаг вэ?	

3) Хадгалалт, түгээлттэй холбоотой асуултууд (хадгалалтын байршил, агуулах сав, хугацаа, нөхцөл, заавар журмууд, чанарын хяналт, түгээлт “логистик”);

Бүтээгдэхүүнүүдийг хаана, хэрхэн хадгалдаг вэ?	
Бүтээгдэхүүнүүдийг дунджаар ямар хугацаагаар хадгалдаг вэ?	
Хадгалалтын ямар заавар журам, нөхцлүүдийг мөрддөг вэ?	
Бордоо, УХБ-ын хадгалалтын үеийн чанарын албан хяналт бодитоор хэрхэн явагддаг вэ?	
Бордоо, УХБ-ын түгээлтийг хэрхэн зохион байгуулдаг вэ?	

4) Борлуулалттай холбоотой асуултууд (худалдан авагчид, борлуулалтын хугацаа, жилд борлуулах хэмжээ бүтээгдэхүүн ба худалдан авагч буюу худалдан авагчдын бүлэг тус бүрээр, худалдан авагчдын зүгээс тавих чанарын шаардлага, нийлүүлж буй бүтээгдэхүүнүүдийн талаар худалдан авагчдын мэдлэг, борлуулах дундаж үнэ, худалдан авагчдад үзүүлэх үйлчилгээ, бүтээгдэхүүнүүдийн зах зээлийн потенциал, борлуулалтын SWOT);

Танай ААН-ийн борлуулдаг бүтээгдэхүүнүүдийн гол худалдан авагчид (%)?	
Жилийн аль хугацаанд ямар бүтээгдэхүүнүүд хамгийн их борлогддог вэ?	
Борлуулалтын дундаж хэмжээг бүтээгдэхүүн ба худалдан авагчдын бүлэг тус бүрээр илэрхийлнэ үү.	
Жилд борлуулах хэмжээг бүтээгдэхүүн тус бүрээр илэрхийлнэ үү.	
Худалдан авагчдын зүгээс чанарын ямар шаардлагууд тавьдаг вэ?	
Бүтээгдэхүүн тус бүрийг ямар дундаж үнээр борлуулдаг вэ?	
Худалдан авагчдад нэмэлт үйлчилгээ санал болгодог уу (жишээ нь зөвлөх үйлчилгээ)?	
Бүтээгдэхүүн тус бүрийн зах зээлийн потенциалыг та хэрхэн үнэлэх вэ?	
Борлуулалтад ямар бэрхшээлүүд учирдаг вэ?	

5) Зах зээлийн өрсөлдөөнтэй холбоотой асуултууд (өрсөлдөгчид, тэдгээрийн давуу ба сул талууд, зах зээлд эзлэх хувь хэмжээ, өрсөлдөөний стратеги);

Зах зээл дэх гол өрсөлдөгчдөө нэрлэнэ үү.	
Танай өрсөлдөгчид ямар давуу, сул талуудтай вэ?	
Өрсөлдөгчид бүтээгдэхүүн тус бүрээр зах зээлд ямар хувь хэмжээ эзэлдэг вэ?	
Төрөөс зах зээлд хэрхэн оролцдог вэ (жишээ нь импортын хяналт г.м.)	

6) Зах зээлийн цаашдын төлөвтэй холбоотой асуултууд (зах зээлийн төлөв бүтээгдэхүүн тус бүрээр, худалдан авагчдын зүгээс тавих чанарын шаардлагад гарах магадлалтай өөрчлөлтүүд, зах зээлийн өрсөлдөөний цаашдын төлөв).

Бүтээгдэхүүн тус бүрийн зах зээлийн цаашдын төлөв байдлыг та хэрхэн үнэлэх вэ?	
Худалдан авагчдын зүгээс тавих шаардлагуудад өөрчлөлт гарч буй эсэхийг ажигласан үү?	
Бордоо, ургамал хамгааллын бодисын хэрэглээг нэмэгдүүлэх ямар арга замууд байж болох вэ?	